"ЦЭГЦ ТӨВ БОГД АУДИТ" ХХК-НИЙ
ГОВЬ-АЛТАЙ ДАХЬ САЛБАР
82091 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг
Утас: 91838373

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ,ЕСӨНБУЛАГ
СУМЫН "ИХ ЦАЛУУ" ББСБ-ЫН
ЗАХИРАЛ Д.ЦЭЛМЭГ ТАНАА

2022 оны 07 сарын 17 № 02

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, Төрийн аудитын тухай хуулийн 6-р дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Компаны тухай, Хоршооны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай,Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-алтай аймгийн "Их цалуу" ББСБ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн үйл ажиллагааны тайланг анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэлтэй тулган шалгаж баталгаажуулах санхүүгийн тайлангийн аудит хийв.

"Их цалуу" ББСБ-ын 2022оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдал,санхүүгийн үр дүн,цэвэр /хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон орлого, үр дүн, зардлын гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай, Компаны тухай, Хоршооны тухай, ББСБ-ын тухай,Татварын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, НББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударага илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Хараат бус аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан/ажлын гүйцэтгэл/ материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээнэ.

Дээрх ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт зорилтод түвшний төлөвлөгөө 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Ажлын гүйцэтгэлд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар "Их цалуу" ББСБ-ын 2022 оны жилийн эцсийн зээлийн хүүгийн орлого, зардлын гүйлгээ,бусад орлого, зардлын гүйцэтгэл, санхүүгийн тайлан дрхь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт,програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж,аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Ажил гүйцэтгэгч нь Компани, Хоршооны тухай хууль болон төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, зэрэгт заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн аж ахуйн нэгжийн орлого, зарлагын гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь хараат бус аудитын байгууллагын үүрэг юм.

ЗАХИРАЛ, АУДИТОР С.ГАЛСАНЧОЙМБОЛ

2022 оны санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүд

"их цалуу" ББСБ

(Банк бус санхүүгийн байгууллага)

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 сарын 31

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэглэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ		
Мөнгөн хөрөнгө	22,463,994.00	149,824,220.00
Нийт зээл	733,615,773.00	890,598,218.00
(Зээлийн эрсдрийн сан)	- 20,048,042.00	- 14,297,460.55
БУСАД АВЛАГА	13,402,797.00	22,838,660.00
БУСАД ХӨРӨНГӨ	51,000.00	51,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	**749,485,522.00**	**1,049,014,637.45**
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,234,491.89	13,683,298.12
Биет бус хөрөнгө	1,430,421.68	1,201,729.62
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,664,913.57	14,885,027.74
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**765,150,435.57**	**1,063,899,665.19**
БОГИНО ХУГАЦАА ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	125,000,000.00	304,000,000.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4,484,615.66	9,476,339.33
ХУВЬЦААТ КАПИТАЛЫН ДҮН	600,000,000.00	600,000,000.00
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	35,665,813.91	35,665,813.91
ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	635,665,813.91	750,423,325.86
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	**765,150,429.57**	**1,063,899,665.19**
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
ХҮҮГИЙН ОРЛОГО	234,567,843.00	336,608,211.85
ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	15,148,673.00	16,425,500.00
ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	35,671,920.00	29,626,932.00
Боловсон хүчинтэй холбоотой зардал	46,428,100.00	67,224,500.00
Бусад зардал	122,096,761.48	111,738,867.84
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО ЗАРЛАГЫН ДҮН	**- 153,376,188.48**	**- 162,537,867.84**
БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН САН БАЙГУУЛАХААС ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ /АЛДАГДАЛ/	45,519,734.52	114,757,511.95
БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН ЗАРДАЛ	86,552.40	2,074,457.55
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ /АЛДАГДАЛ/	45,433,182.12	112,683,054.40
ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ /АЛДАГДАЛ/	5,804,500.00	15,042,400.00
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ /АЛДАГДАЛ/	39,628,682.12	127,508,346.61
ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	3,962,868.21	12,750,834.66
ЦЭВЭР АШИГ	**35,665,813.91**	**114,757,511.95**
ЭЗДИЙН ӨМЧИЙН ТАЙЛАН		
Хувцаат капитал	600,000,000.00	600,000,000.00
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	35,665,813.91	150,423,325.86
НИЙТ ДҮН	**635,665,813.91**	**750,423,325.86**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**- 232,913,091.66**	**146,922,626.00**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын тайлан	1,515,826,643.00	2,061,730,080.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагын тайлан	1,748,739,734.66	1,914,807,454.00
ҮЙЛ БУС АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**175,195,500.00**	**- 15,042,400.00**
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний орлогын дүн	181,000,000.00	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний зарлагын дүн	5,804,500.00	15,042,400.00
ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	**- 57,717,591.66**	**131,880,226.00**
Мөнгөн ба түүнтэй адилдах хөрөнгийн эхний үлдэгдэл	**28,639,715.92**	**22,463,994.04**
Мөнгөн ба түүнтэй адилдах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**- 29,077,875.74**	**154,344,220.04**

АУДИТОР: С.ГАЛСАНЧОЙНБОЛ

НЯГТЛАН БОДОГЧ: Б.ДАШМАА